

ДОТООДЫН ХЯМРАЛТ БАЙДАЛ БА НИЙТИЙН ЭМХ ЗАМБАРААГҮЙ БАЙДЛЫН ҮЕД ЗЭВСЭГТ ХҮЧНИЙГ ОРОЛЦУУЛАХ АСУУДАЛД

PARTICIPATION OF THE ARMED FORCES FOR INTERNAL CRISIS AND PUBLIC DISORDER



Б.НЭРГҮЙ

Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн Иргэн-цэргийн харилцаа судлалын төвийн эрдэм шинжилгээний ажилтан, хошууч, докторант

NERGUI B.

The institute for defence studies center for Civil-military relations research Researcher, Doctorate, Major



Г.ГАН-ЭРДЭНЭ

Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн Иргэн-цэргийн харилцаа судлалын төвийн эрдэм шинжилгээний ажилтан, дэслэгч

GAN-ERDENE G.

The institute for defence studies center for Civil-military relations studies Researcher, lieutenant

Abstract: Mongolia has developed human rights, freedom and justice since adopted a new Constitution. According to its situations the political parties, civil society organizations and citizens have organized peaceful movement and expressing their perceptions freely.

Historically few of activities approached the public disorder, we assume that it will be more likely negative approach in the future.

Throughout the world, particularly in emerging democracies and developing countries restore social challenges for a social crisis and public disorder, and consequently the country's crisis and internal anarchy were common.

The armed forces, usually involves increasing support in times of crisis, such as border military, police force.

This decision of the government of the countries of the Constitution, international treaties and agreements, and coordinate the activities of the Armed Forces of the other laws and regulations are based.

Participation of the armed forces for internal and foreign countries, by the United Nations resolutions and decisions to based on other legislation.

Key words: Social crisis, internal crisis, public disorder, anarchy in social.

Монгол Улс хүний эрх, эрх чөлөө, шударга ёсыг дээдэлсэн хүмүүнлэг, иргэний, ардчилсан нийгэм байгуулах зорилт дэвшүүлэн шинэ Үндсэн хуулиа баталж, иргэд тайван замаар хуран цуглах, үзэл бодлоо илэрхийлэх, төр засгийн үйл ажиллагааг шүүмжлэх эрх чөлөөтэй болсноос хойш нам улс төрийн хүчнүүд, иргэний нийгмийн байгууллагууд, иргэд олон жагсаал, цуглаан зохион байгуулж, үзэл бодлоо илэрхийлж байна. Түүнээс нийтийн эмх замбраагүй байдал, хямралт байдалд

хүргэсэн нь цөөн боловч сүүлийн жилүүдэд олон нийтийн жагсаал, цуглаан нь тийм хандлагыг агуулах нь илүүтэй болж байна. Үүний тод илрэл нь 2008 оны 7 дугаар сарын 1-ний үйл явдал, Гал үндэстэн холбооны тэргүүн Ц.Мөнхбаярыг баривчлан хориход хүргэсэн үйлдэл зэрэг юм.

Дэлхий нийтэд, ялангуяа ардчиллыг шинээр болон сэргээн хөгжүүлж буй улс орнуудын нийгэмд тулгарч буй хүндрэлүүдийн нэг нь нийгмийн хямралт ба нийтийн эмх замбараагүй байдал болж, түүнээс улбаатай улс орны хямралт байдал, дотоод дахь үймээн самуун нийтлэг болов. Үүний жишээ нь: 2010 онд Египет улсад болсон нийтийн эмх замбараагүй байдал, 2014 онд Украин улсад үүссэн үндсэрхэг үзлээс үүдэлтэй эмх замбараагүй байдал, 2015 онд АНУ-ын Өмнөд Каролина мужийн Чарльстон хотод арьс өнгөөр ялгаварлан гадуурхахын эсрэг нийтийг хамарсан эмх замбараагүй байдал, 2014 онд Тайланд улсад явагдсан сонгуулийн үр дүнг эсэргүүцсэн нийгмийн эмх замбараагүй байдал гэх мэт.

Нийгмийн хямралт байдал гэдэг нь: Нийгэм дэх улс төр-нийгмийн харилцаа хурцадмал байдалтай болж, улмаар хэт даврах үзэл буюу төрт улсын бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдалд аюул учруулах, нийгмийн институтуудын хэвийн ажиллагааг алдагдуулах магадлал ихсэх бодит байдал¹ хэмээн тодорхойлсон байна.

Нийтийг хамарсан эмх замбараагүй байдал гэж: Олныг хамарсан үймээн самуун, эвдэн бусниулах, галдан шатаах, эд хөрөнгө устгах, галт зэвсэг, тэсэрч дэлбэрэх бодис хэрэглэх буюу төрийн төлөөлөгчийг зэвсэглэн эсэргүүцэх үйл ажиллагаа нөхцөл байдлыг ойлгоно.²

Мөн нийгмийн эмх замбараагүй байдлыг Цэргийн нэр томьёоны тайлбар тольд "олон нийтийг хамарсан эсэргүүцлийн хууль бус ажиллагаа. Олон нийтийн зүгээс жагсаал цуглаан зохион байгуулах, энэ явцад эд хөрөнгийг сүйтгэх, шатаах, эвдлэн бусниулах, гал түймэр тавих, тэсэрч дэлбэрэх бодис, төхөөрөмж ашиглах, дээрэм тонуул хийх зэргээр эхлэх бөгөөд улмаар төр, засгийн байгууллагын зохион байгуулалтыг сарниулах, нэр хүндийг унагаах, төрийн болон төрийн бус, олон нийтийн байгууллагын зүтгэлтэн, төлөөлөгчдөд халдах, амь нас, эд хөрөнгийг сүйтгэхэд хүрдэг. Нийгмийн эмх замбараагүй байдалыг үүсгэгч, зохион байгуулагчид, үймээн самууныг дэгдээхдээ олон түмний итгэл үнэмшил, шашин шүтлэг, сүсэг бишрэл, үндэстэн, ястан хоорондын харилцааны хүндрэл бэрхшээл, ядуу баяны эрс тэс ялгаа, нийгэм, эдийн засгийн хүндрэл бэрхшээл, нийгмийн шудрага бус байдал зэргийг ашигладаг"³ хэмээн тодорхойлсон байна.

Хямралын тухай асуудал нь байнга мөргөлдөөнтэй холбогдож, түүнээс үүдэлтэй үүсэж байдаг. Харин мөргөлдөөн нь нийтийг хамарсан эмх замбараагүй байдлыг үүсгэж байдаг байна.

Хямрал нь нийгэм дэх мөргөлдөөн гүнзгийрч, хурцдах, улс оронд түгшүүртэй байдал эрс нэмэгдэхэд илэрч гарах нийгэм, эдийн засаг, улс төрийн онцлог төлөв байдал юм.

Мөргөлдөөний тухай АНУ-ын мөргөлдөөн судлаач Жесси Бернард (Jessie Bernard), Английн социологч Перси Коэн (Persy Cohen), Дарендорф (Dahrendorf), Оросын судлаач Е.М.Бабосов, Польшийн Ежи Вятр (Jerzy Wiatr) нар

¹ "Цэргийн нэр томьёоны тайлбар толь" 192 дугаар тал

² Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмын 2010 оны 4 дүгээр сарын 2-ны өдрийн 173 дугаар тушаалын 2-р хавсралтын 414.2 дэх заалт

³ "Цэргийн нэр томьёоны тайлбар толь" т 192

болон марксистуудын өгсөн тодорхойлолтууд дахь нийтлэг хандлага, агуулгаар “мөргөлдөөн гэдгийг хоёр буюу түүнээс дээш бие хүн эсвэл нийгмийн доторх бүлэглэл, улс орнууд бие биедээ тодорхой зорилгод хүрэх болон материаллаг хийгээд материаллаг бус үнэт зүйлс олж авахад шууд ба шууд бусаар саад хийх, өрсөлдөгчдөө ашиг сонирхлоо хэрэгжүүлэх боломж өгөхгүй байх, эсвэл тэдний үзэл бодол, нийгмийн байр суурийг өөрчлөхөд чиглэсэн идэвхтэй үйлдэл, тэмцлийг ойлгож” байна.⁴

Монгол Улсад болзошгүй дотоод хямрал нь ардчилсан нийгмийн хөгжлийн шилжилт, өөрчлөлт бүрэн төгс явагдаж дуусаагүй байгаатай холбоотойгоор олон шинж чанартай байх төлөвтэй байна.

Өнөөгийн ардчилсан нийгэмд мөргөлдөөн ил тод, шинж чанар нь өөр болжээ. Монгол оронд дараах агуулга бүхий мөргөлдөөн өнөө болон ирээдүйд зонхилох төлөвтэй байна. Үүнд:

1. Үндэсний орлогыг дахин хуваарилахтай холбоотой буюу цалин, тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээг нэмэгдүүлэх шаардлага тавьсан ард иргэд болон төр засаг хоорондын;

2. Төрийн захиргааны хүнд суртал, авилга, хээл хахуулийг эсэргүүцсэн ард иргэд болон засаглалын субъект хоорондын;

3. Нийгмийн тэгш байдал, шударга ёс алдагдсан асуудалтай холбоотойгоор үүсэх ард түмэн болон төр засгийн төлөөлөл хоорондын;

4. Газар эзэмших, өмчлөхтэй холбоотой, ялангуяа хот сууринд буй газар дээр зөвшөөрөлгүй байшин барилга барих болон газрын асуудал хариуцсан төрийн түшмэдийн газрын хууль бус арилжаа, наймааг эсэргүүцсэн оршин суугч иргэд болон төр, орон нутгийн засаг захиргаа хоорондын;

5. Газрын хэвлийн ашигт малтмал олборлолтын эдийн засаг, санхүүгийн үр ашгийн хуваарилалттай холбоотой төр засаг, уул уурхайн компани болон “эх орончдын” хоорондын;

6. Экологийн шинжтэй буюу уул уурхайн компаниудаас байгаль орчныг сүйтгэж буй, нөхөн сэргээлт хийхгүй байгааг эсэргүүцсэн орон нутгийн ард иргэд болон олборлогч аж ахуйн нэгж хоорондын;

7. Төсвийн болон орон нутгийн засаг захиргааны байгууллагуудын эрх мэдлийн хуваарилалтын гажуудалтай холбоотой эрх үүргийн;

8. Сонгууль, сонгох, сонгогдох эрх, түүний үр дүнд төр, нам, ард иргэдийн хоорондын.⁵

Гэвч мөргөлдөөн болгон нийтийн эмх замбраагүй байдал, хямралт байдалд хүргэдэггүй байна.

Монгол Улсад гадаад хүчин зүйлээс эх үүсвэртэй хямралт байдал үүсэж болох талтай. Энэ нь дараах уламжлалт бус цэргийн аюултай холбоотой байж болох юм.

Үүнд:

- Олон улсын терроризм дэлхийн өнцөг булан бүхэнд түгэн тархаж, аюулт байдлыг үүсгэж буйтай холбоотой терроризмын аюулын улмаас дотоодод хямралт байдал гарах;

- Зэвсгийн тархалт, ялангуяа үй олноор хөнөөх зэвсгийн хөнөөлт үр дагаварын улмаас үүсэж болох хямралт байдал;

⁴ Р.Болд.Мөргөлдөөний тухай УБ., 2008, т.52

⁵ Р.Болд.Мөргөлдөөний тухай УБ., 2008, т.214

- Дотоодын үймээн самуун газар авч, төр засгийн удирдлага, олон нийтийн хооронд учир холбогдол нь тодорхойгүй нийгмийн эмх замбараагүй байдал үүссэнээс улбаатай хямралт байдал.

Дээр дурдсан уламжлалт бус цэргийн аюултай холбоотой үүсэж болох цэрэг-улс төрийн хямралаас гадна дараах нөхцөл байдал дотоодод үүсч бий болох нь цэрэг-улс төрийн хямралд хүргэх эх сурвалж болох талтай гэж үзэж байна. Үүнд:

- Хууль бус зэвсэглэсэн бүлэглэл үүсэн байгуулагдаж, нийгэм, төрийн байгуулал болон төр, засгийн тогтолцоог эсэргүүцэх, төр, засгийн эрх мэдлийн төлөө тэмцэх болсоноос;

- Улсын хилийн хяналт, шалгалт (техник тоног төхөөрөмж нь хоцрогдох, хяналт шалгалтын бие бүрэлдэхүүний мэргэшил, ур чадвар хоцрогдох, хариуцлага нь сулрах г.м.), хууль тогтоомжийн хэрэгжилт (хуулийн хариуцлага тооцох заалт, хуулийн байгууллагын ажилтнуудын хариуцлага сулрах г.м.) суларч хар тамхины болон дамын наймаа, зохион байгуулалттай гэмт хэргийн бүлэглэл үүссэнээс;

- Нийгмийн дотор эмх замбараагүй байдал бий болж, төр, засгийн болон хууль хяналтын байгууллагад нөлөөлсөнөөс;

- Төр, засгийн эрх мэдэл нэг улс төрийн хүчнээс нөгөөд шилжих, сонгууль явуулах үед олон нийтийг хамарсан замбараагүй байдлыг төрийн тусгай албаныхан зохицуулж чадалгүй газар авахуулсанаас;

- Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжийг эсэргүүцэх, шинэчлэх, төр, засгийн тогтолцоог өөрчлөх гэсэн хүчирхийлэл нийгэмд үүссэнээс;

- Монгол Улсын хил, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг задлах, тусгаарлах гэсэн салан тусгаарлах, экстермист, тулгуур үзэлт шашны бүлэглэл бий болсоноос;

- Стратегийн объект, бүтээгдэхүүн, уул уурхай, нөөц, мэдээлэл, суурь бүтцийг гадаадын хөрөнгө оруулагчдын эрх мэдэлд алдах, тэдгээрийн хэвийн ажиллагааг алдагдуулах зэргээр үндэсний язгуур эрх ашигт харш бодлого, үйл ажиллагаа явагдсанаас;

- Монголын ард, иргэдийн орлого, ажил, үйлчилгээ багасаж, ядуурал газар авсаны улмаас төр, засгийн бодлого, үйл ажиллагааг эсэргүүцэх жагсаал, цуглаан олшрох, олон нийтийн хөдөлгөөн, холбоод шинээр байгуулагдах, намуудын үзэл баримтлал, стратеги, тактикийн зааг ялгаа ихсэх зэргээр төр, засгийн хууль ёсны байгууламжийг татан буулгах, удирдлагын бүрэлдэхүүнийг олноор огцруулах гэсэн оролдлого ихэссэнээс;

- Хар тамхи, дамын наймаа, зохион байгуулалттай гэмт хэргийн бүлэглэл бий болсоноос;

Дээр дурдсан дотоод дахь учир шалтгаануудаас гадна “хил дамнасан хямрал” гарч болохыг үгүйсгэх аргагүй байна. Цэрэг-улс төрийн хүчирхийллийн болон олон улсын терроризмын гэх мэт хил дамнасан аюул нь илрэх хэлбэр, байрлалын хувьд дотоодын шинжтэй боловч цаад эх үүсвэр, өдөөн зохион байгуулагч нь гадаадынх байж болох юм. Тийм хямралын эх булаг олон улсын хэмжээнд өсөх хандлагатай байгаа бөгөөд тэдгээрээс дараах нөхцөл байдал нь манай улсын хувьд тохиолдож болзошгүй юм.

Үүнд:

- Олон улсын терроризм оргонох, дамжин өнгөрөх, тэдний хамсаатан, гар хөл бологчид бий болох;

- Галт зэвсэг, тэсрэх дэлбэрэх бодисын худалдаа, импортод тавих төрийн хяналт сулаас зэвсгийн наймаа дэлгэрэх, үй олноор хөнөөх зэвсгийг улсын хил нэвтрүүлэх, тийм зэвсэг үйлдвэрлэх, зохион бүтээх зэрэг сөрөг ажиллагаа явагдах;
- Зэргэлдээх улс орны нутаг дэвсгэр дээр албан болон албан бус зэвсэглэсэн бүлэглэл байгуулж, улмаар манай нутаг дэвсгэрт нэвтрэн орох;
- Үндэстэн, ястны салан тусгаарлах, шашны тулгуур үзэлтнүүдийг шууд болон дам дэмжигч гадны нөлөө үйл ажиллагаа бий болох;
- Хар тамхи, дамын наймаа, зохион байгуулалттай гэмт хэргийн бүлэглэл улсын хилээр нэвтрэх боломж бүрдэх;
- Мэдээлэл, сэтгэл зүйн хямралыг Монгол Улсад үүсгэх гадаад нөхцөл байдал бий болох.

Дотоодод үүсэж бий болох хямрал бүхэн цэрэг-улс төрийн хямрал болж хувирах албагүй, болохгүй гэсэн бас баталгаа байхгүй байна. Харин гадаад нөхцөл байдал, түүний нөлөөгөөр, бас “хил дамнасан хямрал”-ууд цэрэг-улс төрийн хямрал үүсэхэд нөлөөлөх магадлал нь их юм.

Цэрэг-улс төрийн хямралын цэргийн талын асуудал: Хямрал нь зэвсэгт мөргөлдөөн болон хувирах аюулыг байнга өөрт агуулж байдаг нь цэргийн арга хэрэгсэл ашиглахад хүргэдэг. Мөргөлдөөн, нийтийн эмх замбраагүй байдал, хямралын үед төрийн удирдлага шийдвэр гаргахдаа алдаа гаргах, үндэслэл, тооцоог ул суурьтай, зөв гаргаж чадаагүй, цэргийн оролцоо, сүр хүч үзүүлэх ажиллагааг буруу зохион байгуулах, хэтрүүлэх, ялангуяа хязгаарлагдмал байдлаар цэрэг оролцуулах, эсрэг талынхаа хариу үйлдэлийг оновчтой тогтоож чадаагүй, ухрах, няцах, тэрслэн босох, зэвсэглэн тэмцэх арга хувилбарыг урьдчилан харж чадаагүй зэргээс улбаалан цэрэг-улс төрийн хямрал зэвсэгт мөргөлдөөнд шилжиж болох талтай байдаг. Цэрэг-улс төрийн хямралын үеийн цэргийн асуудал нь хямралын улс төр-дипломатын арга хэмжээ үр дүнгээ өгөөгүй нөхцөлд явагдахад хүрдэг. Иймээс хямралын үед цэрэг оролцуулах асуудалд тун хянамгай хандахын учир зүй оршдог байна.

Монгол Улсад гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам хамгаалах (нийтийн эмх замбраагүй байдлыг таслан зогсоох), олон нийтийн аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүргийг цагдаагийн байгууллага гүйцэтгэхээр хуульчлагдсан.

Харин Зэвсэгт хүчнийг хямралын үед гол төлөв дотоодын болон хилийн цэрэг, цагдаагийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, хүч нэмэгдүүлэх зорилгоор оролцуулдаг байна. Тэгэхдээ энэ талын шийдвэрийг төр засаг нь тухай тухайн улсуудын үндсэн хууль, олон улсын гэрээ, хэлэлцээр, Зэвсэгт хүчний үйл ажиллагааг зохицуулж буй бусад хууль, тогтоомжид тулгуурлан гаргадаг ажээ. Өөрөөр хэлбэл, Зэвсэгт хүчнийг улс орны дотоодод болон гадаад орнуудад хууль ёс, дэг журам сахиулах, энхийг сахиулах, дэмжих ажиллагаанд оролцуулахдаа Үндсэн хууль болон НҮБ-ын тогтоол, шийдвэр, бусад хууль тогтоомжийг үндэслэн гагцхүү хуулийн хүрээнд шийдвэрлэдэг байна.

Хямралт байдал болон нийтийн эмх замбраагүй байдлын үед Зэвсэгт хүчнийг ашиглах тухай:

Нэг. Монгол Улсын Зэвсэгт хүчнийг ашиглах эрх зүйн асуудлыг тайван цагийн, дайны цагийн гэсэн хоёр өөр нөхцөлөөр авч үздэг. Энэ нь Зэвсэгт хүчний үүргээ гүйцэтгэх үедээ ашигладаг хэрэгсэл, арга ажиллагаатай нь холбоотой гарч ирсэн асуудал юм.

Гэтэл өнөө үед тайван болон дайны цагийн аль алинд байдаг тийм цэрэг-улс

төрийн нөхцөл үүсэх нь олонтаа тохиолддог болжээ. Хямралын болон терроризмын үед нийгэмд тайван болон дайны үед тохиолддог нөхцөл байдал үүсч байна. Үүнтэй холбоотойгоор Зэвсэгт хүчний гүйцэтгэх үүрэг, түүнийг ашиглах байдал дахь урьд өмнөх үеийн тодорхой зааг ялгааг эргэж харах шаардлага хэрэгцээ бий болж байна.

Одоо дагаж мөрдөж буй хууль эрх зүйнд орчинд тайван цагт Зэвсэгт хүчнийг ашиглах тухай:

1. Зэвсэгт хүчний тухай хууль
2. Онцгой байдлын тухай
3. Терроризмтой тэмцэх тухай

Зэвсэгт хүчний тухай хууль: хуулийн 4 дүгээр зүйл дэх Зэвсэгт хүчний чиг үүрэг гэсэн хэсэгт: “4.2. Зэвсэгт хүчин энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан зэвсэгт хүчний үндсэн чиг үүргээс гадна тайван цагт дараах үүрэг хүлээнэ:

4.2.3. байгалийн болон нийтийг хамарсан гамшиг, үйлдвэрийн ослын аюул, хөнөөх хэрэгслийн хөнөөлийн голомтод байгаа хүн ам, эд баялагийг авран хамгаалахад болон тогтоосон хорио цээрийн дэглэмийг сахиулахад туслах;

4.2.6. улсын онц чухал объектыг хамгаалахад дэмжлэг үзүүлэх;

4.2.7. хүмүүнлэгийн үйл ажиллагаанд туслалцаа, дэмжлэг үзүүлэх;

4.2.8. энхийг сахиулах олон улсын хамтын ажиллагаанд оролцох;

4.2.9. хуулиар тогтоосон бусад үүрэг гүйцэтгэх” [Батлан хамгаалах салбарын хууль тогтоомжийн эмхтгэл] гэсэн заалт байдаг.

Зэвсэгт хүчин эдгээр үүргээ биелүүлэхэд бэлтгэлжилтээ хангах, болзошгүй хувилбар, нөхцөл байдлыг урьдчилан харж, үүрэг гүйцэтгэхэд шаардагдах зэвсэг, техник хэрэгсэл, арга тактикийг боловсруулах нь бидний нэг гол үүрэг. Түүнийг бий болгох эрх зүйн орчинг бий болгох шаардлагатай.

Энэ үүднээс нийтийг хамарсан эмх замбараагүй байдал, цэрэг-улс төрийн хямралын үед ашигладаг бидэнд өнөөдөр байхгүй, харин хөгжилтэй улс орнуудад түгээмэлд тооцогдох болсон олон янзын зэвсэг, хэрэгсэл байдаг. Тэдгээр зэвсэг, хэрэгслийн тоонд хийн буу, даралтат зэвсэг, үхэлд үл хүргэх зэвсэг ордог байна. Ийм зарчимд үндэслэсэн байлдааны зэвсэг, техник хэрэгсэл ч байдаг. Түүнийг, нийтийг хамарсан эмх замбараагүй байдал бий болсон, цэрэг-улс төрийн хямралын үед ашиглаж болох ч эрх зүйн зохицуулалт алга байна. Тийм зэвсгийн тоонд химийн нулимс асгаруулах, хорсгох, цацах зэвсэг хэрэгсэл ордог.

Онцгой байдлын тухай: хуулийн 12 дугаар зүйл дэх Онцгой нөхцөл, түүний үр дагаврыг арилгахад цэргийн зарим анги, байгууллагыг татан оролцуулах гэсэн хэсэг дотор, “1. Энэ хуулийн 4 дүгээр зүйл (Ерөнхийлөгч онц байдал зарласан бол)-д заасан онцгой нөхцөл, түүний үр дагаврыг арилгах, нийгмийн амьдралыг хэвийн болгоход нутгийн захиргааны болон цагдаа, дотоодын цэргийн хүч хэрэгсэл хүрэлцэхгүй байгаа тохиолдолд дор дурдсан арга хэмжээг хэрэгжүүлэхэд зэвсэгт хүчин, хилийн цэргийн зарим анги, байгууллагыг татан оролцуулж болно”, “3. Энэ зүйлийн 1 дэх хэсгийн 1-д заасан арга хэмжээ (хуулийн 16 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1, 2, 3, 5, 6, 7; 3 дахь хэсгийн 1, 2, 3, 5, 6, 7, 8, 9-д заасан арга хэмжээнүүд)-г хэрэгжүүлэхэд оролцож байгаа зэвсэгт хүчин, хилийн цэргийн анги, байгууллага, тэдгээрийн бие бүрэлдэхүүн үүрэг гүйцэтгэхдээ хууль тогтоомжоор цагдаа, дотоодын цэрэгт зөвшөөрөгдсөн зэвсэг, тусгай хэрэгсэл ашиглах эрх,

үүргийг нь эдэлнэ” [Батлан хамгаалах салбарын хууль тогтоомжийн эмхтгэл] гэсэн заалт байдаг.

Терроризмтой тэмцэх тухай: хуулийн 10 дугаар зүйлийн “Террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагаанд оролцох байгууллагын хүч хэрэгсэл” гэсэн заалт дотор, “10.2. Шаардлагатай тохиолдолд Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчийн зөвшөөрлөөр Зэвсэгт хүчний ерөнхий зориулалтын цэргийн томилогдсон анги, салбарыг террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагаанд татан оролцуулна” [Батлан хамгаалах салбарын хууль тогтоомжийн эмхтгэл] гэсэн заалт байдаг.

Дээрх хоёр хуулийн доторх “татан оролцуулж болно” гэсэн заалт, “бие бүрэлдэхүүн үүрэг гүйцэтгэхдээ хууль тогтоомжоор цагдаа, дотоодын цэрэгт зөвшөөрөгдсөн зэвсэг, тусгай хэрэгсэл ашиглах эрх, үүргийг нь эдэлнэ” гэсэн заалтууд бол зэвсэгт хүчин мөн л хавсарга хүчин байх тухай заалтууд юм.

Дээрх хоёр бүлэг хууль дахь зэвсэгт хүчнийг тайван цагт ашиглах тухай заалтууд нь ерөнхий, “болно”, “үүрэг хүлээнэ”, “оролцоно”, “хэрэгжүүлнэ” гэсэн шинжтэй байгаа нь тэдгээр заалтыг тодруулах шаардлага байгааг бас нотлон харуулж байна.

Эдгээр хуульд “Террористуудтай тэмцэхэд”, “цэрэг-улс төрийн хямрал үүсэхэд”, Дотоодын бослого, үймээн гарч онцгой байдал зарлахад, Зэвсэгт хүчнийг ашиглах тухай, зэвсэгт хүчин дайны болон тайван цагийн холимог шинжтэй үүргээ хэрхэн биелүүлэх тухай заалтуудыг оруулаагүй байна.

Хямралт байдал нь дайн, зэвсэгт мөргөлдөөн эхлээгүй, тийм нөхцөлд шилжээгүй, “дайны өмнөх нөхцөл”-д байгаа нийгмийн онцгой байдал юм. Улсын дотоодод бий болсон эмх замбараагүй байдал, хурцадмал үе, хүч хэрэглэсэн үйл ажиллагаа, иймэрхүү бусад үйлдлийг зэвсэгт мөргөлдөөнд тооцохгүй, иймээс Олон улсын зэвсэгт мөргөлдөөний хууль, эрх зүйн заалтад хамаарахгүй ажиллагаа юм.

Ийм нөхцөлд, “Террористуудтай тэмцэх”, “цэрэг-улс төрийн хямрал үүсэх”, “Онцгой байдал зарлах”, “дотоодын бослого, үймээн гарах” үед Зэвсэгт хүчнийг ашиглах нь Олон улсын бус, нэг улсын дотоод дахь хууль эрхийн актаар зохицуулагдах асуудал юм.

Өнөөгийн хууль зүйн нөхцөл байдал нь хуулиар хориглоогүй бүхэн зөвшөөрөгдсөнд тооцоох уу? эсвэл хуулиар эрх, үүргийг тогтоогоогүй учир зэвсэгт хүчин “холимог” шинжтэй үүргийг биелүүлэхгүй байх уу? гэсэн асуулт гарч ирэхээр байна. Ийм асуулт гарах нь зүйн асуудал. Аль алин нь нийгэм болон зэвсэгт хүчинд ихээхэн хохирол учруулахад хүрнэ.

Хоёр. Гадаад хүчин зүйлээс үүдэлтэйгээр буй болж болзошгүй дараах хямралт байдлын үеийн эрх зүйн зохицуулалт өнөө хэр хийгдээгүй байна гэж үзэх үндэстэй байна. Үүнд:

- Зэргэлдээх улс орны нутаг дэвсгэр дээр албан болон албан бус зэвсэглэсэн бүлэглэл байгуулж, улмаар манай нутаг дэвсгэрт нэвтрэн орохоос үүдэлтэй;
- Үндэстэн, ястны салан тусгаарлах шашны тулгуур үзэлтнүүдийг шууд болон дам дэмжигч гадны нөлөө, үйл ажиллагаанаас үүдэлтэй;
- Гадны нөлөөгөөр явагдах мэдээлэл, сэтгэл зүйн дайнаас үүдэлтэй хямралт байдлын эрх зүйн орчны асуудлыг хамааруулан дурдаж болох юм.

Гурав. Дотоод хүчин зүйлээс улбаатайгаар үүсэж болзошгүй хямралт байдлуудын дотроос нэн түрүүнд эрх зүйн зохицуулалт шаардаж буй дараах аюулын төрөл буй гэж үзэж байна. Үүнд:

- Нийгмийн дотор эмх замбараагүй байдал бий болж, төр засгийн

удирдлага, олон нийт хооронд үл ойлголцол үүссэнээс улбаатай;

- Үндэсний орлогыг дахин хуваарилахтай холбоотой буюу цалин, тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээг нэмэгдүүлэх ард иргэдийн шаардлага, төр засгийн эсэргүүцэлээс үүдэлтэй;

- Төрийн захиргааны хүнд суртал, авилга, хээл хахууль газар авч, нийгмийн тэгш бус байдал, шудрага ёс алдагдсан асуудалтай холбоотойгоор үүсэх;

- Газар эзэмших, өмчлөх, зөвшөөрөл олгоход гарч буй хууль бус ажиллагаанаас үүдэлтэй;

- Газрын хэвлийн ашигт малтмал олборлолтын эдийн засаг, санхүүгийн үр ашгийн хуваарилалт, байгаль орчны нөхөн сэргээлттэй холбоотойгоор ард иргэдийн илэрхийлсэн эсэргүүцлээс үүдэлтэй;

- Стратегийн объект, бүтээгдэхүүн, уул уурхай, нөөц, мэдээлэл, дэд бүтцийг гадаадын хөрөнгө оруулагчдын мэдэлд алдах, тэдгээрийн хэвийн ажиллагааг алдагдуулах зэргээр үндэсний эрх ашигт харш бодлого, үйл ажиллагаа явагдсанаас үүсэх;

- Монголын ард, иргэдийн орлого, ажил, үйлчилгээ багасаж, ядуурал газар авсны улмаас төр, засгийн бодлого, үйл ажиллагааг эсэргүүцэх олон нийтийн хөдөлгөөн, жагсаал, цуглаан олширсноос үүдэлтэйгээр үүсэж болзошгүй хямралт байдлуудын эрх зүйн зохицуулалтын асуудлыг авч үзэх шаардлагатай байна.

Дөрөв. Улс дотор бослого, үймээн гарсан, террорист халдлагад өртсөн, цэрэг-улс төрийн хямрлын үед Зэвсэгт хүчнээр тайван цагт “холимог” үүрэг гүйцэтгүүлэхэд:

Нэгдүгээрт, зэвсэгт хүчин үүргээ биелүүлэхэд ямар зэвсэг хэрэгсэлтэй байхыг зохицуулж өгөх;

Хоёрдугаарт, энэ зэвсэг хэрэгслийг ашиглан явуулах үйл ажиллагааны хэм хэмжээг тогтоож өгөх;

Гуравдугаарт, Зэвсэгт хүчнийг ашиглах үеийн операци, штабын удирдлага, харилцан ажиллагааг тодорхой зохицуулж өгөх;

Дөрөвдүгээрт, хүний эрх, иргэдийг хамгаалахтай холбоотой асуудлыг зохицуулах гэсэн гурван бүлэг үндсэн асуудлын хүрээнд байх болов уу гэж бид үзэж байна.

Эх сурвалжийн жагсаалт.

1. Батлан хамгаалах салбарын хууль тогтоомжийн эмхтгэл III. 2004. – 558х;
2. Женевийн конвенц. УБ., 1995. (Дайны үед энгийн хүн амыг хамгаалах тухай Женевийн конвенц. т151;
3. Женевийн конвенц. УБ., 1995. Олон улсын зэвсэгт мөргөлдөөнд хэлмэгдэгсдийг хамгаалахтай холбогдолтой конвенц. т 229;
4. Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэл. УБ, 2008
5. Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь. УБ., 2008. Боть III.-х1858;
6. Р.Болд. Мөргөлдөөний тухай УБ., 2008.-480х, ISBN 978-99929-3-080-2;
7. Хямралт байдлын үед зэвсэгт хүчнийг ашиглах эрх зүйн орчинг боловсронгуй болгох арга замууд. Төслийн тайлан. БХЭШХ, 2009 он
8. Цэргийн нэр томьёоны тайлбар толь. БХЭШХ, 2014 он
9. Ш.Паламдорж, Л.Бямбасүрэн. Дайны тухай онол, сургамж. УБ., 2001.- 352х;
10. Я.Мягмарсүрэн. Зэвсэгт мөргөлдөөний хууль. УБ., 2003.-300х;
11. Батлан хамгаалагчдыг хэн, хэрхэн хянах вэ? Гарын авлага. УБ., 2004 он